

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Аудит хийгдсэн байгууллага:

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагуудад
Тайлангийн хэсгээс

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР :

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2015 оны эхний 8 сарын
хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудит

Аудитын хугацаа: 2015.09.02- 10.20

Ажлын баримт:
3003/16

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА
АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫН ЖАГСААЛТ

2015 оны 10 дугаар сарын 22

Аудит хийгдсэн нэгж:

Нийслэлийн "Биеийн тамир спортын газар"

Дотоод аудитын нэгж: Гүйцэтгэлийн аудитын хэлтэс

Дд	Илэрсэн асуудлууд	Дүн /мянган төгрөгөөр/	Зөвлөмж	Дүгнэлт
1	2	3	4	5
ЗОРИЛТ 2:				
1	<p>1. НБТСГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг өөрийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан, мэдээ гаргаж ажиллаагүй, хөтөлбөрийн 2.4.14-т заагдсан арга хэмжээг хариуцсан мэргэжилтэн хэрэгжүүлээгүй нь тус газрын даргын A/31 дүгээр тушаалын 2 дах "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын тайлан, явцын мэдээг 2015 оны 06 дугаар сарын 11-ний дотор гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай", 3 дах "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын тайлан, явцын мэдээг шаардлагын дагуу, цаг хугацаанд нь гаргаж танилцуулахад хяналт таөвж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай" заалтууд хэрэгжээгүй.</p>		Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах;	
ЗОРИЛТ 4:				
2	<p>1. НБТСГ нь Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн тэмцээний зардлыг батлагдсан төсвөөс 4,447.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 47.3 "Энэ хуульд заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна" заалт хэрэгжээгүй.</p>	4 447,5	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;	
	Зөрчлийн дүн	4 447,5		

АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН "БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР"-ЫН
ДАРГА

/Ж.ГАНБОЛД/

НЯГТЛАН БОДОГЧ

/О.ЭРДЭНЭЦЭЦЭГ/

Тэмдэг

Ажлын баримт:
3004/16

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА
АУДИТЫН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ
2015 оны ... сарын ...

Аудитад хийгдсэн нэгж:
Нийслэлийн "Биеийн тамирын газар"

Дотоод аудитын нэгж: Гүйцэтгэлийн аудитын хэлтэс

Зорилтууд	Зөвлөмж	Хариу арга хэмжээний төлөвлөгөө	Дуусгахаар төлөвлөсөн хугацаа	Хариуцах хүн
2	Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах;			
4	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;			

АУДИТ ХИЙГДСЭН:

Нийслэлийн "Биеийн тамирын газар"
Нягтлан бодогч

тэмдэг

A handwritten signature consisting of stylized characters, likely the initials J.K. followed by Ganbold.

/Ж.ГАНБОЛД/
/О.ЭРДЭНЭЦЭЦЭГ/

Дэд зорилт 3.1.2. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлд /тайлагнал/ үнэлэлт, дүгнэлт өгөх;

- Шалгуур:**
- a. ТБОНӨХБАҮХАТ хууль;
 - б. НИТХ-ын 2014 оны 19/24 дүгээр “Хөтөлбөр батлах тухай” тогтоол;
 - в. НЗД-ын 2014 оны А/956 дугаар “Нийслэлийн аялал жуулчлалын зөвлөл байгуулах тухай” захирамж;
 - г. НЗД-ын 2015 оны А/198 дугаар “Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай” захирамж;
 - д. НЗД-ын 2015 оны А/121 дүгээр “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамж;
 - е. Нийслэлийн Аялал жуулчлалын зөвлөлийн ажиллах журам;
 - ё. Бусад холбогдох тушаал, шийдвэрүүд.

Бодит нөхцөл байдал:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР

Тус хөтөлбөрийн хүрээнд НБТСГ нь дангаар 4, хамтарч 1 ажлуудыг хийхээр төлөвлөгдсөн байна.

НБТСГ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хөтөлбөрийн заалт	Арга хэмжээний нэр	Зохион байгуулах хэлбэр	Тайлбар
2.3.20	Тив, дэлхий, олон улсын томоохон тэмцээн уралдаан зохион байгуулах шаардлага хангасан спортын цогцолборыг хувийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах явдлыг газар олголтын бодлогоор дэмжих	Хамтарсан /НӨХХГ, НЕТГ/	Хэрэгжсэн
2.4.14	Нийслэл орчмын хүүхдийн зуслангуудыг түшиглэн спортын зуны олон улсын цугларалт, хамтарсан бэлтгэл зохион байгуулах боломжийг бүрдүүлэх	НБТСГ	Хэрэгжээгүй
2.6.4	Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн тэмцээн	НБТСГ	Хэрэгжсэн
2.6.4	Дугуйн марафон	НБТСГ	Хугацаа хойшлогдсон
A/198 дугаар захирамжаар	Дуулиан 2020	НБТСГ	Хэрэгжсэн

Дээрх арга хэмжээнүүдээс 3 нь хэрэгжсэн, дугуйн марафон нь хугацаа хойшлогдож, 2.4.14-т заагдсан арга хэмжээ хэрэгжээгүй байна. 2.4.14-т заагдсан “Нийслэл орчмын хүүхдийн зуслангуудыг түшиглэн спортын зуны олон улсын цугларалт, хамтарсан бэлтгэл зохион байгуулах боломжийг бүрдүүлэх” ажлыг хариуцсан мэргэжилтэн хангалтгүй ажилласнаас шалтгаалсан байна.

НБТСГ-ын дарга 2015 оны 06 дугаар сарын 09-ний өдөр А/31 дүгээр тушаал гаргаж тус хөтөлбөрт тусгагдсан өөрийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан, явцын мэдээ гаргах, хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан боловч уг тушаал хэрэгжээгүй байна.

Шалтгаан:

- НБТСГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг өөрийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан, мэдээ гаргаж ажиллаагүй, хөтөлбөрийн 2.4.14-т заагдсан арга хэмжээг хариуцсан мэргэжилтэн хэрэгжүүлээгүй нь тус газрын даргын А/31 дүгээр тушаалын 2 дах "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын тайлан, явцын мэдээг 2015 оны 06 дугаар сарын 11-ний дотор гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай", 3 дах "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын тайлан, явцын мэдээг шаардлагын дагуу, цаг хугацаанд нь гаргаж танилцуулахад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай" заалтууд хэрэгжээгүй.

Үр нөлөө:

- Тус газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг өөрийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний явц, тайлан мэдээг гаргаж ажиллаагүй нь тус хөтөлбөрийн хүрээнд НБТСГ-аас хэрэгжүүлэх ажлууд цаг хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлүүдийг үүсгэсэн.

Дэд зорилт 3.1.4. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын санхүүгийн тайлagnal, зарцуулалт, түүний үр дүн, өгөөжид үнэлэлт, дүгнэлт өгөх;

Шалгуур: а. Төсвийн, ТБОНӨТ, НББ-ийн тухай хуулиуд;
б. ЗГ-ын 129 дүгээр тогтоол;
в. НИТХТ-дийн 2014 оны 66 дугаар тогтоол.

Бодит нөхцөл байдал:

Хэрэгжүүлсэн арга хэмжээнд түүвэр аудит гүйцэтгэхэд хөтөлбөрийн хүрээнд бий болсон зарим хөрөнгийг орлогод аваагүй, НЗД-ын захирамжаар батлагдсан төсвийг хэтрүүлэн болон зориулалт бусаар зарцуулсан дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

- “НБТСГ-аас зохион байгуулсан Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн тэмцээн 118,550.0 мянган төгрөгөөр батлагдсан байхад тэмцээний зардал 4,447.5 мянган төгрөгөөр хэтэрсэн.

Шалтгаан:

- НБТСГ нь Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн тэмцээний зардлыг 4,447.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 47.3 “Энэ хуульд заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна”, 42.7. “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь

шилжүүлэх, төсөөт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Үр нөлөө:

- Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн тэмцээний зардал хэтэрсэн нь үргүй зардлыг санхүүжүүлэх, төсвийн орлого, зардлыг дутуу төлөвлөх эрсдэлийг үүсгэсэн.

3.3. ЗӨВЛӨМЖ

- Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

БЭЛТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
АХЛАХ ШИНЖЭЭЧ
АУДИТОР



Ж.ЖАМБАЛДОРЖ
Н.НАРАНЧИМЭГ
Ц.ДУЛАМДОРЖ

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ

ДАРГА



Д.НАЦАГДОРЖ